



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/219

Номгон

Г Терроризмтой тэмцэх зөвлөлийн Г
аймаг дахь салбар зөвлөлд
дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 460 дугаар тогтоолоор батлагдсан Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажиллах журмын 7.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Терроризмтой тэмцэх зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах 15,000,000 (Арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

3.Үйл ажиллагааг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг аймгийн Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа (Л.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-д даалгасугай.



626010581